



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ТӨХК-ийн нийтэд санал
болгон нэмж гаргасан үнэт цаасыг үнэт цаасны
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ТӨХК-ийн нийтэд санал болгон Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 294 дүгээр тогтоолоор нэмж гаргасан 32,373,000 /гучин хоёр сая гурван зуун далан гурван мянга/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалагсугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00 27